

Since
1906★

**Сүгмөн Эмэгтэйчүүдийн
их сургууль 2024 оны 3 сарын элсэлт
Бакалаврын сургалтын гадаад
оюутны элсэлт**



숙명여자대학교
SOOKMYUNG WOMEN'S UNIVERSITY

Элсэлтийн явц	2024 оны 3 сарын элсэлт		Анхаарах зүйл
	1 дэхь элсэлт	2 дэхь элсэлт	
Онлайнаар бүртгэл	2023.10.4(Лха) 10:00 ~2023.10.16(Да) 17:00	2023.12.4(Да) 10:00 ~2023.12.13(Лха) 17:00	http://e.sookmyung.ac.kr → Admission → Undergraduate
Материал хүлээн авах эцсийн хугацаа	2023.10.20(Ба)	2023.12.20(Лха)	Доорх хаягаар илгээх эсвэл биечлэн өгөх Administration Building #706 Office of International Affairs Sookmyung Women's University 100, Cheongpa-ro 47-gil, Yongsan-gu, Seoul, Korea (04310) Онлайнаар бүртгүүлсэн материалуудаа хэвлэн бусад бичиг баримтуудтай хамт хүлээлгэн өгнө. Бүрдүүлэх материалуудаа дарааллын дагуу цэгцлэн хүлээлгэн өгнө. (4. Бүрдүүлэх бичиг баримт хэсгээс харах)
Ярилцлагын хуваарь болон байршил	2023.11.1(Лха)	2023.12.27(Лха)	http://e.sookmyung.ac.kr Сургуулийн вебсайт руу орж шалгах
Аман шалгалт	2023.11.3(Ба)	2024.1.3(Лха)	*Урлаг спорт салбарын тэнхим Бүжиг, Төгөлдөр хуур, Симфони найрал хөгжим, Дуулаач, Хөгжмийн ая зохиогч, Дүрс бичлэг мультимедиа дизайн, Үйлдвэрийн дизайн, Хүрээлэн буй орчны дизайн -Ярилцлага эхлэхээс 30 минутын өмнө хүрэлцэн ирэх -Шалгалтын хуудас болон үнэмлэхээ авч ирэх -Урлаг спортын тэнхим нь ур чадварын шалгалтыг хамт нэмэлтээр өгөх магадлалтай.
Ярилцлагын хариу	2023.11.15(Лха)	2024.1.12(Лха)	http://e.sookmyung.ac.kr Сургуулийн вебсайт руу орж шалгах
Бүртгэл	2024.1~2сар		Бүртгэлийн хуваарь болон төлбөрийн талаар мэдээллийг тэнцсэн элсэгчдийг зарласны дараа мэдэгдэнэ
Хичээл эхлэх	2024.3сар		

- Өргөдөл гаргагч заавал онлайнаар өргөдөл бөглөх шаардлагатай. Онлайнаар өргөдөл бөглөх боломжгүй бол бичгээр бөглөх боломжтой.
- Онлайнаар өргөдөл бөглөсний дараа өргөдөл болон бусад бичиг баримтуудыг биечлэн эсвэл шуудангаар илгээнэ.
- Өргөдөл гаргагч бичиг баримтуудаа заасан хугацаанд багтаан илгээх шаардлагатай. Заасан хугацаанаас хойш хүлээн авсан материал хүчингүйд тооцогдох магадлалтай учир бичиг баримтаа эртнээс бэлтгэхийг анхааруулж байна.
- Шалгаруулалтын комисс бичиг баримтуудыг шалган тус бүрчлэн хариуг мэдэгдэхгүй боловч нэмэлт материал шаардах, материалтай холбоотой лавлах зорилгоор өргөдөл гаргагчтай холбоо барьж болох учир холбогдох утасны дугаараа тодорхой бичихийг хүсье

[Солонгос хэлний чиглэл]

Сургууль	Тэнхим		Шинээр элсэгч	Шилжин элсэгч	Англиар сонсох	
Глобал нэгдсэн их сургууль	Глобал нэгдсэн тэнхим		○	х	Гадаад оюутнуудад зориулсан тэнхим() 2025 оны хичээлийн эхний хагас (3сар) элсүүлэх хугацаанд тэнхимийн нэр өөрчлөгдөх төлөвтэй байна.	
Хэл шинжлэл, уран зохиолын их сургууль	Солонгос хэл, уран зохиол		○	○		
	Түүх, соёл судлал		○	○		
	Франц хэл, соёл судлал		○	○		
	Хятад хэл, уран зохиол		○	○		
	Герман хэл, соёл судлал		○	○		
	Япон судлал		○	○		
	Номын сан, мэдээлэл бүртгэл		○	○		
Байгалийн шинжлэх ухааны их сургууль	Соёл, аялал жуулчлал		○	○		
	Соёл, аялал жуулчлал		○	○		
	Биологийн шинжлэх ухаан		○	○		
	Хими		○	○		
	Математик		○	○		
Инженерийн их сургууль	Статистик		○	○		
	Бүжиг*		○	○	Ярилцлага болон практик шалгалт	
	Химийн болон биологийн инженер		○	○		
	ICT нэгдсэн Инженер	Мэдээллийн технологийн инженер		○	○	
		Электроникийн инженер		○	○	
		Хэрэглээний физик		○	○	
	Компьютерийн шинжлэх ухаан	Компьютерийн шинжлэх ухаан		○	○	
		Програм хангамжийн нэгдэл		○	○	
	Механик систем Инженер		○	○		
	Үндсэн шинжлэх ухааны инженер		○	○		
Өрхийн шижлэх ухааны их сургууль	Гэр бүлийн менежмент		○	○		
	Хүүхэд халамж, хамгаалал		○	○		
	Хувцас, бөс даавуу судлал		○	○		
	Хүнс, хоол тэжээл судлал		○	○		

Хүмүүнлэгийн шинжлэх ухааны их сургууль	Улс төр, олон улсын харилцаа	○	○	
	Удирдлагын ухаан	○	○	
	Зар сурталчилгаа, реклам	○	○	
	Хэрэглэгчийн эдийн засаг	○	○	
	Нийгмийн сэтгэл судлал	○	○	
Хууль зүйн их сургууль	Хууль зүй	○	○	
Эдийн засаг, менежментийн их сургууль	Эдийн засаг	○	○	
	Бизнес менежмент	○	○	
Хөгжмийн сургууль	Төгөлдөр хуур*	○	●**	Ярилцлага болон практик шалгалт
	Симфони найрал хөгжим*	○	●**	Ярилцлага болон практик шалгалт
	Дуулаач*	○	○	Ярилцлага болон практик шалгалт
	Хөгжмийн ая зохиогч*	○	○	Ярилцлага болон практик шалгалт
Урлагийн сургууль	Дүрс бичлэг, мультимедиа дизайн*	○	○	Ярилцлага болон практик шалгалт
	Үйлдвэрлэлийн дизайн*	○	○	Ярилцлага болон практик шалгалт
	Хүрээлэн буй орчны дизайн*	○	○	Ярилцлага болон практик шалгалт
	Гар урлал*	○	○	Ярилцлага болон практик шалгалт
	Уран зураг*	○	○	Ярилцлага болон практик шалгалт
Глобал сервис их сургууль	Глобал хамтын ажиллагаа	○	○	
	Энтрепренершип	○	○	
Англи хэл, уран зохиолын их сургууль	Англи хэл уран зохиол	○	○	
	TESL-ээр мэргэших (ТЕСОЛ)	○	○	
Медиа, харилцаа холбооны сургууль		○	○	

[Англи хэлний]

Сургууль	Тэнхим	Шинээр элсэгч	Шилжин элсэгч	Англиар сонсох
Глобал үйлчилгээний тэнхим Global Service	Глобал хамтын ажиллагааны чиглэл Global Cooperation	○	○	
	Энтрепренёршипийн (бизнес эрхлэлт) мэргэжил Entrepreneurship Major	○	○	

1. Шинээр элсэгчид**А. Иргэншил**

- Эцэг эх нь хоёулаа гадаад эмэгтэй оюутан байх
 - ※ Өргөдөл гаргагч солонгосын иргэншлээ гадны иргэншлээр сольж байсан тохиолдолд, энэ нь ахлах сургуулийн элсэлтээс өмнө байх
 - ※ Давхар солонгосын иргэншилтэй гадаад иргэн өргөдөл гаргах боломжгүй

В. Боловсролын түвшин

- Ахлах сургууль төгссөн байх

С. Хэлний түвшин

- ТОПИК-н 3 болон түүнээс дээш түвшинтэй байх
- Сүгмён глобал хэлний бэлтгэлийг 3 болон түүнээс дээш түвшинд суралцсан байх(суралцах)
- Сүгмён глобал хэлний бэлтгэлийн солонгос хэлний шалгалтанд 3 болон түүнээс дээш түвшинд тэнцэгч
- Англи хэлээр хичээл сонсох элсэгч нь ТОПИК оноогүй байж болох ба TOEFL CBT 197, IBT 71, IELTS 5.5, TEPS 600 , New TEPS 326 ба түүнээс дээш мөн үүнтэй дүйцэх англи хэлний түвшин тогтоох шалгалтын оноотой байх

2. Шилжин элсэгчид

Шилжин элсэгч нь шинээр элсэгчидтэй адил дээрх шаардлагуудыг хангахын зэрэгцээ доорх шаардлагуудыг хангах хэрэгтэй.

А. 3-р курсэд шилжин суралцагч нь: Доорх 1-3 нэгийг нь хангасан байх

- 1) 4 жилийн сургалттай их дээд сургууль төгссөн (төгсөх ангийн оюутан байх)
- 2) 4 жилийн сургалттай их дээд сургуульд 2 жилээс илүү суралцсан байх, 60 кредитээс илүү судласан байх
- 3) Тусгай мэргэжлийн сургууль төгссөн байх(төгсөх ангийн оюутан байх)

Б. 2- курсэд шилжин суралцагч

- 1) 4 жилийн сургалттай их дээд сургуульд 1 жилээс илүү суралцсан байх, 30 кредитээс илүү судласан байх

3. Глобал нэгдсэн тэнхим

Глобал нэгдсэн тэнхим нь зөвхөн гадаад оюутнуудад зориулагдсан тэнхим бөгөөд 2 дахь мэргэжлээрээ сонгон судлах боломжтой. Глобал нэгдсэн тэнхимд элсэх оюунтууд нь үндсэн сургалтанд шаардагдах солонгос хэлний ахисан шатны чадварыг эзэмшиж, олон улсын оюутнуудад либерал урлагын үндсэн ур чадварыг хөгжүүлэхэд зориулагдсан хичээлүүдийг үзэх болно.

- Хүсэлт гаргах эрх

ТОПИК 2 болон түүнээс дээш түвшний эзэмшигч

- Ангилал

Курс	1-р курс	2-р курс~4-р курс
Тэнхим	Глобал нэгдсэн тэнхим	Глобал нэгдсэн тэнхим судлалын чиглэлээр ахисан түвшний эсвэл өөр тэнхимийн давхар мэргэжил гэх мэт

※ Зөвхөн 2 болон түүнээс дээш семестр төгссөн глобал нэгдсэн судалгааны тэнхимийн ахисан түвшний болон давхар мэргэжлээр бусад тэнхимүүдийг сонгох боломжтой. Гэсэн хэдий ч эм судлал, соёл аялал зуулчлал, ресторан менежмент, сурган хүмүүжүүлэх ухааны тэнхимүүд нь сонгох боломжгүй.

- Глобал нэгдсэн тэнхимаас олгодог тусгай тэтгэлэг
Элсэн суралцаж байгаа оюутанд эхний семестр 5000000он тэтгэлэг

- Глобал нэгдсэн тэнхимийн сургалтын хөтөлбөр
- 1. Солонгос хэлний мэдлэгтэй байх шаардлагатай

Солонгос хэлний түвшин	Сургалтын явц
Анхан шат	Анхан шат 4 хичээл
Дунд шат	Дунд шат 4 хичээл

- 2. Шаардлагатай ерөнхий боловсролыг дүүргэх

※Дээрх нөхцөл байдалаас шалтгаалан өөр өөр байж болно

4. Хэлний ур чадварын стандарт

Ангилал	Тэнхим	Хэлний стандарт
Солонгос хэл	Глобал нэгдсэн тэнхим	<ul style="list-style-type: none"> - Солонгос хэлний түвшин тогтоох шалгалтын 2 ба түүнээс дээш түвшин, Глобал нэгдсэн тэнхийм хүрээнд дор хаяж 300 цаг солонгос хэлний хичээлд хамрагдах шаардлагатай. - Сүгмён глобал солонгос хэлний сургалтанд 3 ба түүнээс дээш түвшнийг төгссөн байх - Сүгмён глобал солонгос хэлний сургалтанд дүйцүүлэх шалгалтанд заас дээш түвшинд тэнцэх
	Бусад	<ul style="list-style-type: none"> - Солонгос хэлний түвшин тогтоох шалгалтын 3-аас дээш түвшинтэй байх - Сүгмён глобал солонгос хэлний сургалтанд 3 ба түүнээс дээш түвшнийг төгссөн байх - Сүгмён глобал солонгос хэлний сургалтанд дүйцүүлэх шалгалтанд заас дээш түвшинд тэнцэх
		<ul style="list-style-type: none"> - Солонгос хэлний түвшин тогтоох шалгалтын оноо нь дээрх стандартыг хангаагүй элсэлтийн шалгалтад тэнцсэн хүмүүсээр хязгаарлагдана (болзолт) шалгалтын оноог улирал эхлэхээс өмнө өгөх ёстой - Шалгалтын оноо стандартад нийцэхгүй тохиолдолд, сургуулиас чөлөө авч хэлний шалгалтанд тэнцэх ёстой. - Солонгос хэлний дүйцүүлэх шалгалттай холбоотой лавлагаа : linguaexpress@sookmyung.ac.kr
Англи хэл	Глобал сервис их сургууль, Глобал хамтын ажиллагаа, Энтрепренершип	<ul style="list-style-type: none"> - TOEFL CBT 197, iBT 71, IELTS 5.5, TEPS 600, New TEPS 326 дээш - Эсвэл үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн англи хэлний түвшин тогтоох шалгалтын тэнцэх оноог ирүүлнэ үү.(ТОPIK оноо тооцогдохгүй) - Англи хэлний оноо нь дээрх стандартанд хангаагүй тохиолдолд бүртгүүлэх боломжгүй.

- Засгийн газрын урилгаар тэтгэлэгт суралцаж буй оюутнууд болон гадаадын засгийн газрын тэтгэлгээр суралцаж буй оюутнууд урилгын өргөдлийн шаардлага, академик удирдлагын удирдамжийг дагаж мөрдөнө.
- Дээрх хэлний мэдлэгийн стандартыг үл харгалзан дараах стандартыг хангасан хэлний мэдлэгтэй гэж бусад дагалдах баримт бичгээр хүлээн зөвшөөрсөн хүмүүс хэлний мэдлэгийн оноо өгөхгүйгээр хүсэлт гаргаж болно.
- Сүгмён глобал солонгос хэлний сургалтанд суралцан авсан 3 болон түүнээс дээш түвшиний гэрчилгээ эсвэл дүйцүүлэх шалгалтний 3 болон түүнээс дээш түвшинд тэнцсэн гэрчилгээг бүрдүүлэн өгөх. Элсэлтийн шалгалтанд тэнцсэнээс хойш 1 жилийн дотор ТОPIK-ийн 3-р түвшний нэмэлт гэрчилгээг өгөх ёстой. Сүгмён глобал солонгос хэлний сургалтанд дүйцүүлэх шалгалтанд 3 болон түүнээс дээш түвшинд тэнцсэн сурагч нь тэтгэлэгт хамрагдах боломжгүй.

- Англи хэл нь төрөлх хэл эсвэл албан ёсны хэлтэй улсын иргэншил(Англи хэлний тэнхимд хамрагдах хүсэлтэй хүмүүст хаягаарлагдмал) . Гэсэн хэдий ч англи хэлнээс бусад хууль ёсны албан ёсны хэлтэй орнуудад сургалтын хөтөлбөрийг англи хэл дээр явуулсан болохыг баталгаажуулсан баримт бичгийг ирүүлэх ёстой.
- **※ Элсэн суралцагч нь төгсөхөөсөө өмнө ТОPIK 4 (Урлаг бие тамирийн хувьд ТОPIK 3 болон түүнээс дээш түвшин) болон түүнээс дээш түвшинд хүрэх ёстой(Англи хэлний тэнхим нь хамаарагдахгүй)**

4

Бүрдүүлэх материал

1. Зайлшгүй шаардлагатай бичиг баримт

Шаардлагатай бичиг баримт	Тайлбар
Анкет	Онлайнаар анкет бөглөсний дараа хэвлэх [Form 1]
Бүртгэлийн хураамж (5 дугаар хэсгээс харах)	<ul style="list-style-type: none"> - Солонгосоос өргөдөл гаргагч : Shinhan Bank 140-007-271166 - Гадаададаас өргөдөл гаргагч: Доорх дансруу шилжүүлнэ үү Name of Bank : Shinhan Bank (Sookmyung Women's University Branch) Account No: 140-007-271166 Swift Code: SHBKKRSE Name of Beneficiary: Sookmyung Women's University Bank Address: 115 Chungpa-dong 3 Ka, Yongsan-ku, Seoul, Korea <p>※ Шилжүүлгийн хураамжийг өргөдөл гаргагч хариуцна ※ Өргөдөл гаргагч заавал өөрийн нэрээр шилжүүлэг хийх шаардлагатай ба бүрдүүлэх бичиг баримтуудтай хамт гүйлгээний баримтаа илгээнэ үү</p>
Сурах төлөвлөгөө	Англи юм уу солонгосоор бичих [Form 2]
Боловсролын тухай маягт	Англи юм уу солонгосоор бөглөх [Form 3]
Ахлах сургууль төгссөн гэрчилгээ болон дүнгийн тодорхойлолт (жил бүрээр) Хятадын ахлах/дээд сургууль төгссөн тохиолдолд хуудас 6-г харах	<ol style="list-style-type: none"> 1. Апостиль гэрчилгээ авах 2. Төгссөн сургуулийн гэрчилгээгээ консулын газраар оруулж баталгаа авах
Өргөдөл гаргагч түүний эцэг эхийн иргэншлийг нотлох бичиг баримт	Жишээ нь: төрсний гэрчилгээ (лавлагаа), төрөл садангийн лавлагаа эсвэл эцэг эхийн паспортын хуулбар
<p>Анхаарах зүйл</p> <ul style="list-style-type: none"> ✦ Өргөдөл гаргагч нь Апостиль гэрчилгээгээр төгсөлтийн гэрчилгээгээ баталгаажуулах шаардлагатай. ✦ Апостиль гэрчилгээгүйгээр зөвхөн төгсөлтийн гэрчилгээний хуулбар мэдүүлэх нь хүчингүйд тооцогдоно ✦ Дүнгийн гэрчилгээ нь; <ol style="list-style-type: none"> ① 100 онооны дүнгийн системээр бодогдсон байх (дүнгийн систем өөр тохиолдолд тайлбар хавсаргах) ② 100 онооны дүнгийн систем биш тохиолдолд төгссөн сургуулиасаа дүнгийн системийн талаарх баталгаат бичиг авч хавсаргах ③ Дүнгийн систем өөр тохиолдолд WES (www.wes.org/students/igpacalc.asp) эсвэл Foreign Credits (www.foreigncredits.com) хаягаар дүнгээ шалган илгээнэ үү ④ Ахлах сургуулиа төгсөөгүй байгаа өргөдөл гаргагч суралцсан семестер хүртэлх дүнгийн гэрчилгээг мэдүүлэх 	

2. Бусад бичиг баримт

Бичиг баримт	Тайлбар
Солонгос хэлний оноо (Солонгосоор хичээл сонсогч)	Тогтоосон хугацаанд багтааж Топик 3 болон түүнээс дээш дүнгийн баталгаа эсвэл Сүгмён глобал солонгос хэлний сургалтанд 3-р түвшин болон түүнээс дээш түвшинг дүүргэсэн элсэгч
Англи хэлний оноо (Англиар хичээл сонсогч)	TOEFL CBT 197, IBT 71, IELTS 5.5, TEPS 600, TEPS 326 ба түүнээс дээш
Гадаад иргэний үнэмлэхний хуулбар	Солонгост оршин сууж буй элсэгчдэд хамааралтай

3. Шилжин элсэгчдийн бүрдүүлэх бичиг баримт

- A. Дээр дурьдсан бүх бичиг баримтууд
 - B. Сурч буй сургуулийн тодорхойлолт
 - C. Дүнгийн тодорхойлолт
- Хятадын их дээд сургууль төгсөгч(суралцагч) бол хуудас 6-г харах

4. Бүрдүүлэх материал - анхаарах зүйлс

- A. Материалуудыг эх хувиар нь мэдүүлэх шаардлагатай. Эх хувиар нь мэдүүлэх боломжгүй материалуудын хувьд, нотариат эсвэл апостилиар баталгаажуулсан хуулбарыг мэдүүлэх шаардлагатай.
- B. Бүх бичиг баримт англи эсвэл солонгос хэлээр байх шаардлагатай. Бусад хэл дээрх бичиг баримтуудыг англи юм уу солонгос хэлээр орчуулуулан мэдүүлэх шаардлагатай.
- C. Бүх бичиг баримтыг материал хүлээн авах эцсийн хугацаанд багтаан мэдүүлэх шаардлагатай.
- D. Шаардлагатай тохиолдолд сургуулийн зүгээс нэмэлт бичиг баримт хүсэж болно.
- E. Хараахан төгсөөгүй байгаа өргөдөл гаргагчийн хувьд элсэн орсонхоо дараа нэмэлтээр төгсөлтийн гэрчилгээгээ мэдүүлэх шаардлагатай.
- F. Шилжин элсэгч нь сургуулиасаа чөлөө авсан байгаа бол сургуулийн тодорхойлолт бус чөлөөний тодорхойлолт мэдүүлэх шаардлагатай.
- G. Өргөдөл гаргагчийн нэр, төрсөн он сар өдөр бүрдүүлсэн бичиг баримтаас зөрсөн тохиолдолд нотлох нэмэлт бичиг баримт мэдүүлэх шаардлагатай.
- H. Мэдүүлсэн бичиг баримтуудыг өргөдөл гаргагчид буцаан өгөхгүй болно.

Апостиль гэрчилгээний тухай

1. Төгсөлтийн гэрчилгээ болон дүнгийн тодорхойлолтын баталгаа

Өргөдөл гаргагч нь төгсөлтийн гэрчилгээ болон дүнгийн тодорхойлолтоо апостиль гэрчилгээгээр баталгаажуулах шаардлагатай. Апостиль гэрчилгээнд хамрагддаггүй улсын их дээд сургууль төгссөн бол тухайн улсад байрших Солонгосын Элчин сайдын яаманд хандана уу.

www.hcch.net (Hague Conference on Private International Law) цахим хуудасны Апостиль хэсгээс улс тус бүрчлэн холбогдох мэдээллийг авах боломжтой.

Апостиль лавлагааны байгууллага:

- Гадаад харилцааны яам апостиль лавлагааны байгууллага : 02-2100-7600
- Хууль зүйн яам апостиль лавлагааны байгууллага : 02-720-8027

2. Апоcтиль гэрчилгээ

Гишүүн орнуудын жагсаалт (2022.12.07) нийт 122 улс

Бүс	Гишүүн орнууд
Ази, Номхон далай (21)	Австрали, Хятадын зарим хэсэг (Макао, Хонг Конг), Япон, Солонгос, Шинэ Зеланд, Бруней, Монгол, Күүкийн арлууд, Фижи, Энэтхэг, Маршаллын арлууд, Маврики, Вануату, Самоа, Тонга, Ниуэ, Тажикистан, Палау, Филиппин, Сингапур, Индонез
Европ (52)	Албани, Австри, Беларусь, Бельги, Босни-Герцеговина, Болгар, Хорват, Кипр, Чех, Дани, Эстони, Финлянд, Франц, Гүрж, Герман, Мальта, Грек, Унгар, Исланд, Ирланд, Итали, Латви, Литва, Люксембург, Монако, Монтенегро, Нидерланд, Норвеги, Польш, Португал, Орос, Румын, Серби, Словак, Словени, Испани, Швед, Швейцарь, Турк, Киргизстан, Македон, Украин, Их Британи, Андорра, Армен, Азербайжан, Молдав, Лихтенштейн, Сан Марино, Казахстан, Узбекистан, Косово
Хойд Америк (1)	АНУ (Гуам, Мори арлууд, Сайпан, Пуэрто Рико орно)
Латин Америк(31)	Аргентин, Мексик, Панам, Суринам, Венесуэл, Антигуа, Барбуда, Багамын арлууд, Барбадос, Белиз, Колумб, Доминикан, Доминикан, Эквадор, Эль Сальвадор, Гранада, Гондурас, Сент Винсент, Перу, Тринидад ба Тобаго, Сент Люсиа, Сент Люсиа Киттс ба Невис, Коста Рика, Уругвай, Никарагуа, Парагвай, Бразил, Чили, Гватемал, Боливи, Гайана, Ямайка
Ойрхи Дорнод, Африк(17)	Намиби, Өмнөд Африк, Либери, Лесото, Малави, Марокко, Бахрейн, Ботсвана, Бурунди, Саудын Араб, Сан-Томе ба Принсипи, Сейшелийн арлууд, Свазиланд, Оман, Израиль, Кейп Верде, Тунис

※ Өргөдөл гаргагч Хятадад сургууль төгссөн тохиолдолд доорх материалыг бүрдүүлнэ үү

А. Ахлах сургуулийн төгсөлтийн гэрчилгээ

- Хятадын боловсролын гэрчилгээний төв (www.chsi.com.cn) : энгийн/мэргэжлийн/техникийн ахлах сургуулийн гэрчилгээ (англи хэл)

- Хятадын сургалтын зэрэг олгох төв (www.chinadegrees.cn) : энгийн/мэргэжлийн/техникийн ахлах сургуулийн гэрчилгээ (англи хэл)

В. Ахлах/их сургуулийн бүх жилийн дүнгийн гэрчилгээ (www.chsi.com.cn) (www.chinadegrees.cn)

С. Төгсөөгүй байгаа тохиолдолд суралцаж буй тухай гарчилгээ (www.chsi.com.cn)

Анхаарах зүйл: Бүрдүүлэх материал нь дээрх вебсайтын баталгаагүй тохиолдолд хүлээн зөвшөөрөгдөхгүй. Гэрчилгээ олгогдох хугацаа 30 хоног учир урьдчилан бэлтгэхийг хүсье

5

Бүртгэлийн хураамж

1. 150,000ВОН ЭСВЭЛ \$150

2. Бүртгэлийн хураамжийг буцаан олгох боломжгүй

(1) Шалгалт болон онооны хуваарь

Салбар сургууль болон тэнхим		Ярилцлага аман шалгалт	Нийт
Байгалын ухааны их сургууль	Бүжгийн тэнхим	100% (1000ноо)	100% (1000ноо)
Хөгжмийн их сургууль	Төгөлдөр хуурын тэнхим, Симфони найрал хөгжмийн тэнхим, Дуулаачын тэнхим, хөгжмийн ая зохиогчын тэнхим		
Урлагын их сургууль	Дүрс бичлэг мультмедиа дизайн, Үйлдвэрийн дизайн, Хүрээлэн буй орчны дизайн		

* Дээрх тэнхимууд нь чадварын шалгалтыг хамт авах боломжтой (3р бүлэг)

А. Шалгалтын өдөр зоминутын өмнө ирсэн байх.

Б. Шалгалтын хуудас болон биеийн байцаалт авч ирэх.

В. Өргөдөл гаргагч ярилцлаганд өөрийн биеэр оролцох боломжгүй тохиолдолд утсаар/видео дуудлагаар ярилцлага авна.

Салбар сургууль болон тэнхим		Бичиг баримт	Нийт
Дээрх тэнхимээс гадна бүх тэнхимүүд		100% (1000ноо)	100% (1000ноо)
Урлагийн их сургууль	Гар урлалын тэнхим, Уран зургын тэнхим		

3. Урлаг, биеийн тамирын ур чадварын шалгалт авах төрөл

Салбар сургууль	Тэнхим(Мэргэжил)	Ур чадварын шалгалт авах төрөл		Солонгост байхгүй тохиолдолд хэрхэн шалгалт өгөх
Байгалийн ухааны их сургууль	Бүжгийн тэнхим	Солонгос бүжиг (үндэсний, дэглээч)	Хувцас: торгон цагаан юпкатай ханбуг, цагаан хувцас сонгох, цагаан солонгос загварын чишк	Ур чадвараа харуулсан DVD хураалгах, дүрсээ харж ярих (CD юм уу VIDEO болохгүй)
		Баллет	Хувцас : V хүзүүтэй, урт ханцуйтай купалник, оймстой ягаан тирко, ягаан чишк	
		Модерн бүжиг	Хувцас: V хүзүүтэй урт ханцуйтай хар купалник, оймсгүй биеийн өнгөтэй тиркотой, хөл нүцгэн	
Хөгжмийн их сургууль	Төгөлдөр хуурын тэнхим	① Sonata хурдан нэг хэсэг(Piano Solo дуунд хамрах) ② F. Chopin Etude 1ая (удаан аянаас бусад)		Ур чадвараа харуулсан DVD хураалгах, дүрсээ харж ярих (CD юм уу VIDEO болохгүй)
	Симфони найрал хөгжмийн тэнхим	Чөлөөт дуу 1ая(15 минут дотор)		
	Дуулаачийн тэнхим	. Герман дуу (чөлөөтэй) идүү – германаар цээжлэн дуулах . Итали дуу (чөлөөтэй) идүү – италиар цээжлэн дуулах		
	Хөгжмийн ая зохиох тэнхим	3 хэсгээс бүрдэх төгөлдөр хуур дээрх ая бичих		
Урлагийн	Дүрс бичлэг,	Нарийвчилсан харандаан бүтээл(4хэсэг)		Бүтээлийн албумаар нь

их сургууль	мультимедиа дизайн		дүгнэнэ
	Үйлдвэрлэлийн дизайн		
	Хүрээлэн буй орчны дизайн		
	Гар урлал		Солонгост байхгүй хүн оролцох боломжгүй
Уран зураг	Нарийвчилсан зураг(4хэсэг)	Бүтээлийн албумаар нь дүгнэнэ	

4. Давхар мэргэжлийн мэдээлэл (1,2 сонголт)

Глобал нэгдсэн тэнхимд өргөдөл гаргагч нь өөр бусад тэнхим давхар мэргэжлээр сурах хүсэлт гаргах боломжтой.

- Өргөдөл гаргах журам : Эхний болон Хоёр дахь сонголтын тэнхимаа тус тусад нь өргөдөл гаргах шаардлагатай. Шалгалтын дугаар 2 үүсгэх хэрэгтэй. Глобал нэгдсэн тэнхимийг багтаасан 2 тэнхимийг сонгох боломжтой. Өргөдлийн хураамж төлбөрийг тушаах хэрэгтэй.
- Өргөдөл гаргагч нь өргөдөл гаргасан тэнхимд шаардагдах бичиг баримтийг бүрдүүлэх ёстой. Боловсролын түвшин болон дүнгийн хуудас нь эх хувиар 1, хуулбараар 1 ирүүлэх шаардлагатай.
- Давхар мэргэжил сонголтонд өргөдөл гаргагчийн тэнцсэн дүнг баталгаажуулах

Давхар мэргэжил өргөдөл гаргагч хоёр өргөдлийн дугаарын үр дүнг шалгасны дараа нэг тэнхимийн эцсийн сонголтыг хийх ёстой. 1 ба 2-р сонголтыг нэгэн зэрэг хүлээн авах тохиолдолд та бүртгэлээс хасах маягтыг нэг удаа бөглөх ёстой.

7 Тавигдах шаардлага

1. Өргөдөл гаргагч ярилцлаганд ирээгүй бол тэнцээгүүд тооцогдоно.
2. Элсэн суралцагч нь Топик 3 болон түүнээс дээш оноог мэдүүлэх шаардлагатай.
3. Англи хэлээр хичээл сонсох элсэгчид TOEFL CBT 197, IBT 71, IELTS 5.5, TEPS 600, New TEPS 326 ба түүнээс дээш англи хэлний оноотой байх. Дээрхээс өөр олон улсад зөвшөөрөгдсөн англи хэлний шалгалтын оноотой тохиолдолд мэдүүлэх боломжтой.
4. Тэнцсэн хэдий ч хараахан гадаад хэлний оноогоо аваагүй байгаа элсэгчид чөлөө аван оноог мэдүүлэх шаардлагатай.



Дээрх шаардлага бүхий оноотой солонгос болон англи хэлний шалгалтын сертификатгүй оюутан нь элсэлтээр тэнцэж болох ч хичээл эхлэхээс өмнө тухайн англи ба солонгос хэлний шалгалтын үзүүлэлт бүхий сертификатыг заавал хураалгах шаардлагатай. Хэрэв англи ба солонгос хэлний түвшингийн оноо нь дээрх шаардлагад хүрэхгүй тохиолдолд чөлөө авч Сүгмён сургуулийн хэлний бэлтгэлд хамрагдан хэл сурах шаардлагатай.

Онцгой тохиолдол

- (1) Солонгосын болон бусад улсын засгийн газрын тэтгэлгийн оюутнууд тухайн засгийн газраас гаргасан дүрэм журмыг баримтлана.
- (2) Доорх шаардлагуудаас аль нэгийг нь хангаж буй өргөдөл гаргагч гадаад хэлний оноо мэдүүлэхгүй байх боломжтой
 - Лингуа Экспресс-т Солонгос хэлний бэлтгэлийн 4 ба түүнээс дээш түвшинг дүүргэсэн өргөдөл гаргагч
 - Албан ёсны хэл нь англи хэл бүхий улсын өргөдөл гаргагч (Зөвхөн англи хэлээр хичээл сонсогчдоо хамаарна)

※ **Анхаарах зүйл!** Тэнцсэн элсэгчид Сүгмён их сургуулийг төгсөхөөсөө өмнө ТОПИК-н 4 ба түүнээс дээш түвшинг авах шаардлагатай (англи хэлний оноогоор элсэгчдэд хамаарахгүй)

※ Элсэлтийн явц



8 Элсэгчийн анхаарах зүйлс

- (1) Цахимаар бүртгүүлсний дараа үлдсэн бичиг баримтаа очиж өгөх ба, шуудангаар илгээх боломжтой.Төлбөр төлсөн баримтаа заавал цуг илгээнэ.
- (2) Элсэлтийн материалыг хүлээн авах хугацаанаас өмнө бичиг баримтууд сургуульд ирсэн байх шаардлагатай.
- (3) Бүртгүүлэх арга:
 - 3.1 Нэрээ солонгос, ангилаар бичих
 - 3.2 Мэргэжилээ сонгох
 - 3.3 Иргэншил, иргэний үнэмлэхний дугаараа бичих
 - 3.4 Ахлах сургуулийн төгссөн нэр болон төгссөн он сар өдөр
 - 3.5 Элсэгчийн хаяг, гэрийн утас, гар утас
 - 3.6 Элсэгчийн эцэг эхийн хаяг, гэрийн утас, гар утас
 - 3.7 Элсэгчийн и-мэйл хаяг
 - 3.8 Элсэгчийн солонгос хэлний мэдлэгийн түвшин
- (4) Цахимаар бүртгүүлэх элсэгчид цээж зурагаа оруулсан байх
 - Цээж зурагны хэмжээ 3x4cm, сүүлийн 3 сар дотор авхуулсан малгайгүй, цулгуй фонтой энгийн зураг
 - Цээж зургыг зөвхөн JPG файлаар оруулах
 - Оруулсан цээж зурагаа нягталж үзнэ үү. Оруулсан зураг тань оюутны үнэмлэхний зураг болно.
- (5) Элсэгч холбогдох утасны дугаараа заавал бичсэн байх, буруу бичсэнээс холбогдож чадаагүй тохиолдолд сургууль хариуцлага хүлээхгүй.
- (6) Бүрдүүлж өгсөн материал дундаас хуурамч материал илэрсэн үед элсэлтийг цуцлаж хүчингүй болгоно
- (7) Бүртгэлийн хураамж болон хураалгасан материал буцааж олгогдохгүй
- (8) Ярилцлага,аман шалгалтанд ирэхдээ бүртгэлийн дугаартайгаа ирэх,элсэгчийг нотлох баримт бичигтэй ирэх (иргэний үнэмлэх, гадаад паспорт)
- (9) Ярилцлага, аман шалгалт болох газар 30 минут орчмын өмнө ирсэн байх
- (10) Ярилцлага, аман шалгалтнд CD.MP3,гар утас гэр мэтийн цахилгаан хэргэсэл хэргэлэхгүй байх
- (11) Элсэгч тус бүрээс эрүүл мэндийн шинжилгээ авах буюу арга хэмжээ үзүүлэх
- (12) Дээрх элсэлтийн тайлбар нь орчуулсан хувилбар бөгөөд ямар нэгэн асуудал гарсан тохиолдолд солонгос хувилбарыг мөрдөх болно.

А.Гадаад шилдэг оюутанд зориулсан тэтгэлэг

		Солонгос хэл		Англи хэл				
		Солонгос хэлний түвшин тогтоох шалгалт (ТОPIK)	Тус сургуулийн хэлний бэлтгэл	TOEFL (IBT)	IELTS	TEPS	NEW TEPS	TOEIC
Тэтгэлэгийн ангилал	Тэтгэлэг	6-р түвшин	6-р түвшин	120	9.0	990	600	990
A	Төлбөр 70%	6-р түвшин	-	110-дээш	8.0-дээш			
B	Төлбөр 50%	5-р түвшин	6-р түвшин	100~109	7.0~7.5	723-дээш	401-дээш	870-дээш
C	Төлбөр 40%	4-р түвшин	5-р түвшин	80~99	6.0~6.5	619~722	337~400	780~869
D	Төлбөр 30%	3-р түвшин	4-р түвшин	60~79	5.5	600~618	327~336	620~779

➤ Оюутан нь:

- Эцэг, эх нь хоёулаа гадаад иргэн бүхий гадаад оюутан байх
- Удирдагч багшийн итгэмжлэл бичиг эсвэл тухайн улсын тухайн бүс нутгийн нийгэм, боловсрол, соёлын салбарын удирдах багшийн итгэмжлэгдсэн оюутан
- Итгэмжлэл бичиг нь тус оюутан нь тухайн салбарт шилдгээр тодорсон тухай байх.

➤ Бүрдүүлэх материал:

- Нийгмийн идэвхи ба чадварын тухай тэмдэглэл бичиг (Тухайн агуулгыг батлах баримт бичиг хавсаргах), Удирдагч багшийн итгэмжлэл бичиг(Итгэмжлэгчийн нэр, гарын үсэг, тамга тэмдэг)

➤ Элсэлтийн үнэлэх зарчим: Итгэмжлэл бичгийн агуулга, нийгмийн идэвхи чадварын тухай тэмдэглэл бичиг, дүнгийн хүснэгт, гадаад хэлний оноо, ярилцлагын дүн

- ※ Элсэлтийн хураамж болон төлбөрийн хэмжээ нь улирал бүрт мэргэжилээс хамаарсан төлбөрийн стандарт хэмжээг даган мөрдөнө
- ※ Тэтгэлэгт хамрагдах оюутны тоо болон тэтгэлэгийн хэмжээ нь сонгон шалгаруулах зарчим, гадаадын шилдэг оюутны тэтгэлэгийн зарчмыг даган мөрдөнө.
- ※ Сонгон шалгаруулалтаас хамааран оюутны дотуур байрны төлбөр, тээврийн зардал зэрэг зүйлсийг ханган олгож болно.

В. Глобал нэгдсэн тэнхимийн тусгай тэтгэлэг

- Тавигдах шаардлага : Глобал нэгдсэн тэнхимд элссэн оюутан байх
- Тэтгэлгийн дэлгэрэнгүй мэдээлэл

Глобал нэгдсэн тэнхимийн тусгай тэтгэлэг

Глобал нэгдсэн тэнхимд элссэн орсон оюутан	Эхний семестр 50000000
--	------------------------

- Мэдэгдэл

1. Элсэлтийн тэтгэлийг өргөдөл гаргагчаас тусдаа өргөдөл гаргах шаардлагагүйгээр шалгалтаар сонгогдоно.

С. Гадаад оюутны тэтгэлэг(Үндсэн 2-р улирал- 8-р улирал)

- Суралцах хугацаанд тэтгэлэг олгох зарчим

GPA	Тэтгэлэг
4.3	Төлбөр 100%
4.0~4.3 аас доош	Төлбөр 50%
3.5~4.0 аас доош	Төлбөр 30%
3.3 ~3.5-аас доош	Төлбөр 20%

- Суралцах хугацаанд тооцох хичээл нь F үнэлгээ авсан хичээлийг үл тооцон бусад цуглуулсан кредит нь 12 кредитээс дээш цуглуулсан оюутанд тэтгэлэг олгох
- Тогтсон нийт суралцах улирал(8 улирал)-д тэтгэлэг олгох.

■Элсэлтийн лавлагаа, баримт бичгийг илгээх газар

○ хаяг	(04310)서울시 용산구 청파로 47길 100 숙명여자대학교 행정관 203호 국제협력팀
○ утас	+82-2-710-9284/9817
○ цахим хаяг	admission@sookmyung.ac.kr
○ сайт	http://e.sookmyung.ac.kr

10

Сүгмён солонгос хэлний шалгалт

- (1) Бүртгэлийн хугацаа
Сүгмён глобал солонгос хэлний сургалтны вебсайт (<http://lingua.sookmyung.ac.kr>)
- (2) Бүртгүүлэх арга
 - Сүгмён их сургуулийн вебсайтаар дамжуулан бүртгэлүүлэх боломжтой
 - Лавлах утас : +82-2-710-9164/9165, +82-2-710-9817
 - Корона19 цар тархлаас хамааран ур чадварын шалгалтыг онлайнаар авах магадлалтай.
- (3) Шалгалтын хураамж : 500000он

※ Шалгалт болон сертификат олголт

- Шалгалтын өдөр, паспорт болон иргэний үнэмлэх(биеийн байцаалт) шалгах учир бичиг баримтаа авч ирээгүй тохиолдолд шалгалтанд орох боломжгүй.
- Шалгалт дунд зохисгүй үйлдэл гаргахыг хориглох ба гаргасан тохиолдолд хүчингүйд тооцож хасна.
- Сертификат хуурамчаар үйлдсэн тохиолдолд хүчингүйд тооцож хасна.
- Сертификат алга болгосон тохиолдолд дахин олгохгүй.
- Сүгмён хэлний бэлтгэлийн 3 болон түүнээс дээш түвшинг дүүргэсэн сертификат, орлон шалгалт 3 болон дээш түвшин тэнцсэн сертификатыг мэдүүлсэн тохиолдолд элсэж орсны дараа жилийн дотор 3-аас дээш түвшинд тэнцэж мэдүүлэх.

- A. Бүртгэх нөхцөл: эцэг эх нь гадаад иргэншилтэй шинээр элсэгч гадаад оюутан байх
- B. Бүртгүүлэх арга : сургуулийн хомпэйжээр онлайнаар бүртгүүлэх (тэнцсэн оюутнуудыг зарлах үед мэдээллэнэ)
- C. Бүртгэлийн хугацаа : тэнцсэн оюутнуудыг зарлах үед мэдээллэнэ
- D. Дотуур байрны төлбөр (улирлаар, 4сар): 720,000вон ~1,540,000вон
Дотуур байрны төрлөөс хамааран үнийн ялгаатай бөгөөд сургуулийн амралтын хугацаанд дотуур байранд байх тохиолдолд ашиглалтын төлбөр төлөх шаардлагатай
- E. Холбоо барих: +82-2-6325-3100 / inhouse@sookmyung.ac.kr /
<http://dorm.sookmyung.ac.kr/>

※ Бүртгүүлэгчдийн тоо дотуур байрны багтаамжаас хэтрэн дотуур байранд орж чадахгүй тохиолдолд сургуулиас гадуур байрлах газраа бие даан олж бэлтгэх шаардлагатай.